



Хэвлэлийн мэдээ  
2022 оны 4-р сарын 5

Холбоо барих  
9909-1557

## **АмЧам Монголын ээлжит хэлэлцүүлгээр төрийн өмчит компанийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатайг онцлов**

УЛААНБААТАР, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2022 оны 4-р сарын 5-нд “Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн сэргэлт ба өсөлт” сэдэвт хэлэлцүүлэг амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Т. Доржханд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын (ТӨБЗГ) дарга Б. Цэнгэл, АНУ-ын Элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга Жон Ченг, Эдийн засагч Д. Жаргалсайхан (Jargal DeFacto) ба Мандал Санхүүгийн Группийн үүсгэн байгуулагч, эдийн засагч Ө. Ганзориг нар уригдаж санал бодлоо илэн далангуй хуваалцаж, сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлээ. Өнөөдрийн уулзалтад АмЧам Монголын гишүүд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, гадаадын элчин сайдын болон хэвлэлийн төлөөлөл зэрэг 80 гаруй зочид оролцов.

Хэлэлцүүлгийн эхэнд ТӨБЗГ-ын дарга Б. Цэнгэл төрийн өмчийн компанийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлт болон компанийн үр өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар мэдээлэл өглөө. Мөн Засгийн газрын “Шинэ Сэргэлтийн Бодлогын” хүрээнд хийгдэж буй компанийн засаглалын шинэчлэл, хүний нөөцийн шалгаруулалт, албан томилгоо, авилгатай тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй ажлын талаар дэлгэрэнгүй танилцууллаа.



УИХ-ын гишүүн Т. Доржханд хэлэхдээ одоогийн байгаа төрийн тогтолцоо, түүний бүтцэд байгаа Төрийн Өмчит Компани (ТӨК) статустай байгууллагууд нь хувийн хэвшилд бизнес эрхлэх, тендэрт оролцох бололцоог хумих, эрх баригч нарын мэдэлд байгаа нь даруй шинэчлэлт хийх цаг болсныг илтгэж байна. Мөн түүнчлэн хавтайгарсан авилга, хээл хахууль зэрэг асуудлууд нь хувийн хэвшлийн өсөлт, цаашдаа улс эх орны хөгжилд сөргөөр нөлөөлсөөр 30 жил болж байна хэмээн онцоллоо. Төр өөрөө өөртэйгээ бизнес хийх нь зарчмын хувьд буруу бөгөөд хамгийн их татвар төлсөн гэдгээр шилдэг компаниудыг шалгаруулахад төрийн өмчит компаниуд шалгарсан байдаг.

Мандал Санхүүгийн нэгдлийн үүсгэн байгуулагч, тэргүүн Ө. Ганзориг хэлэхдээ төрийн өмчийн компаниуд олон мянган жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийг хөлслөн ажиллуулах боломжтой тул төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны цикл урт хугацааны төлөвлөгөөтэй байж, томоохон компаниуд жил бүр тендер зарладагаа больж, ЖДҮ эрхлэгчидтэй 3-5 жилээр гэрээ байгуулдаг болох хэрэгтэйг онцлон тэмдэглэлээ. Тэрээр мөн хувийн хэвшил болон эдийн засагчид нь төр засагт илүү шийдэмгий дуу хоолойгоо хүргэж, шаардлагыг нэхэж байхыг уриаллаа.



АНУ-ын Элчин Сайдын Яамны Эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга Жон Ченг хэлэхдээ “Монгол Улсын Засгийн Газар нь бусад улс орны засгийн газрын адилаар зохицуулалтын үүргийнхээ хажуугаар ТӨК-ийн ашиг орлогыг нь тогтвортой барих эрмэлзэлтэй байдаг нь түгээмэл. Гагцхүү тэрхүү орлогыг дангаар нь чухалчилж, ашиг хайх арга замаар зохицуулалт хийх нь олон нийт болон бизнес хүрээлэлд тэднийг муугаар харагдуулдаг гэдгийг тайлбарлалаа. Мөн тэрээр өмнөх илтгэгч нарын чухал санаануудыг сайшааж, ялангуяа ТӨК-ийн шинэчлэл, дээр дурьдсан ил тод байдлыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн бэрхшээлүүдийг хамтдаа туулвал илүү үр дүнтэйг цохон тэмдэглэв. Тэрээр мөн Монгол Улсын хөгжлийн загвар нь заавал их гүрнүүдийн туулсан замаар бус, ижил төстэй орнуудтай илүү ойр байх нь үр өгөөжтэйг хэллээ. Тухайлбал Румын улсын ТӨК-ийн шинэчлэл нь амжилттай болсон жишээ олонтой ба заавал

тэдгээрийг татан буулгах бус, олон нийтийн оролцоотой шинэчлэл хийсэн нь оновчтой байгааг онцоллоо.

Бие даасан судлаач, эдийн засагч ДеФакто Д. Жаргалсайхан хувийн хэвшил цаашид илүү үр дүнтэй ажиллахын тулд кластер хэлбэрийг эрчимжүүлж, эдийн засгийн салбар бүрт цэцэглүүлэх нь чухал ач холбогдолтойг тайлбарлалаа. Мөн тэрээр төрийн захиргааны одоогийн бүтэц, арга барил нь хувийн хэвшилд төдийлөн таатай байдаггүйг онцолж томоохон реформ буюу шинэчлэл хийх цаг болсныг уриалав. Тухайлбал Монголд 4 жил тутам шинэчлэгдэх дүрэм журам, хууль хяналт зэргийг тогтвортой байлгахын тулд хамгийн түрүүнд “сонгуулийн хороо” бус “сонгогчдын хороо”-г байгуулж, тухайн байгууллага нь хяналтаа өдөр тутамдаа хийх, механизмыг эхнээс нь бүрдүүлэх хэрэгтэйг онцлон тэмдэглэлээ.



Хэлэлцүүлгийн хаалтын үеэр илтгэгч нарт хувийн хэвшлийн төлөөлөл асуултуудад дэлгэрэнгүй хариултыг өгсөнөөр уулзалт өндөрлөлөө.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.